

ӨСВӨР НАСНЫХНЫ ДУНД ҮЙЛДЭГДДЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

CITIZEN RESPONSIBILITY AND INFORMAL SOCIAL CONTROL IN THE PREVENTION OF JUVENILE CRIMES AND VIOLATIONS

Д.Цэрэнлхам

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга: Өсвөр насныхны хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь тухайн улсад үүсэх олон сөрөг асуудлаас сэргийлэх үндэс болно. Энэ насныхан гэмт хэрэг, зөрчлийн хохирогч эсвэл холбогдогч болох эрсдэл нь маш өндөр байдаг. Энэ зам руу оруулахгүй байх нь зөвхөн гэр бүл, хууль сахиулах байгууллагын үүрэг биш бөгөөд иргэдийн үүрэг хариуцлага өндөр бөгөөд нийгмийн албан бус хяналтын ач холбогдлын талаар дурдсан.

Abstract: Investing in youth development can prevent many problems in the country. For many reasons, this age group is at a very high risk of becoming a victim or participant in violence, crime, or violation.

It is not only the responsibility of the family and the police to prevent them from entering this path, but also the responsibility of citizens and the importance of informal social control.

Түлхүүр үгс: Өсвөр насны хүн, гэмт хэрэг, зөрчил, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа, асуудалд суурилсан үйл ажиллагаа, нийгмийн албан бус хяналт.

Keywords: Teenagers, crime, violation, community-based activities, problem-oriented activities

2021 оны байдлаар Монгол Улсын хүн амын 22.8 хувийг өсвөр насныхан эзэлж байна. Өсвөр нас нь хүүхэд нас ба орь залуу насны хоорондох үе шат бөгөөд дэлхийн улсууд энэ насыг өөр өөр байдлаар тодорхойлжээ.

Өсвөр насныхан бие махбод, танин мэдэхүйн өөрчлөлт, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны хувьд эрсдэлт болон дэмжих хүчин зүйлсээс шалтгаалан хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис хэрэглэх, сургууль завсардах, түгших, сэтгэл гутралд өртөх зэрэг эрсдэлт зан үйл бий болж, насанд хүрсэн бие хүн болж, бүрэн төлөвшиж чадахгүйд хүрдэг байна.

Гэмт хэрэг, зөрчил гэдгийг хууль зөрчих аливаа зан үйл бөгөөд хэрвээ насанд хүрсэн хүн үйлдвэл гэмт хэрэг гэж тодорхойлжээ⁶⁰. Манай улсын хувьд гэмт хэрэг, зөрчлийн шинж, гэмт хэрэг үйлдсэн хүн, хохирогчийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан хууль зөрчсөн аливаа үйлдлийг гэмт хэрэг, зөрчил гэж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг Эрүүгийн хуульд 16, 14 нас байхаар доод хязгаарыг заасан байдаг.

Өсвөр насныхны хувьд нийгмийн хэм хэмжээ, дүрэм журам зөрчсөн үйлдлийг хэвийн үзэгдэл мэтээр үзэх, хүлээн зөвшөөрөх хандлага бусад насныхантай харьцуулахад энэ үед нь хүчтэй илэрдэг байна. Энэ үе нь зөрчилтэй зан үйлийн хэв шинжүүдийг агуулж байдаг. Эдгээр нь гэмт зан үйл бүрэлдэх эхэн үе шат, гэмт хэргийн хор уршиг, гэмт зан үйлээс ангид байх зэрэг өөр хоорондоо ялгаатай хэв шинжээс бүрддэг. Тиймээс эдгээр эрсдэлт зан үйлийг ялгаж салгаж ойлгох, ингэснээрээ хүүхэд насанд тохиолдсон таагүй үйл явдлаас үүдэлтэй, гэмт хэрэг, зөрчил үйлдэх зонхилох шалтгаан болохуйц зан үйлийг таньж мэдэхэд тустай юм.

Хүүхэд, өсвөр насанд илэрч буй зөрчилт, хүчирхийллийн шинжтэй, нийгэмд харш зан үйлийн хэв шинжээс нь насанд хүрээд гэмт хэрэгтэн болох эрсдэлтэй эсэхийг тодорхойлох боломжтой байдаг. Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн

⁶⁰ Brown, B. B., Prinstein, M. J., Encyclopedia of Adolescence. Academic Press. 2011.

цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь орчин цагийн цагдаагийн байгууллагын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор үүссэн шинэ загвар юм.

Харин манай улсын хувьд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд иргэдийн санал, санаачилгыг дэмжих хүрээнд дараах байдлаар тусгаж өгсөн байдаг.

1. Хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судлаачийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа ажилд оролцуулах;

2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх, тухайн үйл ажиллагааг мэдээ, мэдээллээр хангах замаар дэмжлэг үзүүлэх;

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар шинэ техник, технологи зохион бүтээх, үйл ажиллагаанд ашиглахад дэмжлэг үзүүлэх;

4. Хүүхэд, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил эрхэлдэг хуулийн этгээдэд санхүүгийн болон бусад дэмжлэг, тусалцаа үзүүлэх;

5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн санаачилгыг дэмжиж, шаардлагатай бол хэрэгжүүлэх арга хэмжээг авах.

Гэвч цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо муутай, хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал, уламжлалт байдлаар хуулийг хүч хэрэглэн сахиулах гэсэн хандлагаас шалтгаалан иргэд олон нийт, цагдаагийн байгууллагын хоорондын харилцаа хөндийрдөг. Энэ нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад хүндрэл учруулдаг. Харин олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэдэг бөгөөд орчин цагийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шинэ хэлбэр болон хөгжиж байна.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг дараах дөрвөн үндсэн аргаар хэрэгжүүлдэг⁶¹. Үүнд:

1. Зөвлөлдөх;
2. Хамтын ажиллагаа;
3. Зохион байгуулалт;
4. Харилцаа холбоо.

Харин асуудалд чиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь зөвхөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад бий болсон доголдол, дутагдлыг засах, сайжруулахад чиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны шинэ хэлбэр юм. Асуудалд чиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь тодорхой нутагт дэвсгэрт гэмт хэрэг, хүчирхийллийн шалтгаан болж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэдэг. Асуудалд чиглэгдсэн цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд тодорхой орон нутгийн гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл үйлдэгдэж буй статистик болон бусад мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, суурь эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх зорилгоор орон нутгийн оршин суугчидтай хамтран ажиллах, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах үйл ажиллагаа боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх зэрэг арга хэмжээг авна.

Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь тухайн орон нутагт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд маш үр дүнтэй гэдгийг харуулсан олон жишээ, туршлага байдаг. Сэрэмжлүүлж анхааруулахын оронд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны уламжлалт арга барил болох торгох, шийтгэх, таслан зогсоох, эргүүлийн машин, хүн хүчээр хяналт тогтоох зэрэг нь гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, гэмт хэрэг, зөрчил гарч буй үндсэн асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна гэж судлаачид үздэг.

⁶¹ Schneider, S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010. P. 225.

Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь хоорондоо уялдаа холбоотой үйл ажиллагааны загвар бөгөөд өсвөр насныхан болон залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчлийг бууруулах, шалтгаан, нөхцөлийг илрүүлэхэд чиглэсэн цагдаа, олон нийт хамтран, системтэйгээр хослуулан хэрэгжүүлдэг идэвхтэй үйл ажиллагаа юм. Цагдаагийн байгууллага тухайн орон нутагт тулгамдсан асуудлыг судалж, тэдгээрийг шийдэх үр дүнтэй аргыг эрэлхийлсэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж, үр дүнг нь үнэлдэг байх нь чухал юм. Олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй татан оролцуулдгаараа давуу талтай.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол зорилгын нэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн буюу нийгмийн хяналтыг бий болгох юм. Үүнийг нийгмийн албан бус хяналт гэж нэрлэдэг байна. Харин иргэдийн оролцоо гэдэг нь хувь хүн, бүлэг, олон нийт нь өөрсдийн хүсэл зоригийн үндсэн дээр засаг захиргааны нэгж бүрийн түвшиний бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад өөрсдийн эрх ашгийн төлөө шууд ба шууд бусаар тэгш эрхтэйгээр оролцох үйл явц юм.⁶²

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо маш чухал байр суурь эзэлдэг бөгөөд доороос нь дээш хэрэгжүүлэх нөхцлийг хангаж өгдөг.

Хүснэгт №1.Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх алхмуудыг тоймлон харуулсан байдал

Д/д	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх алхам	Авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал	Оролцогч талууд
1	Мэдээлэлгүй байх үе	Ном товхимол тараах, цахим мэдээлэл, сонин, телевизийн мэдээ, уулзалт, тухайн нутаг дэвсгэрийн төлөв байдлын талаарх судалгааны дүнг мэдээлэх, тараах	ЗДТГ, өрхийн эмнэлэг, цагдаагийн газар хэлтэс, тасаг, хэсэг, сургууль, хэсгийн ахлагч, хөршийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага
2	Мэдээллээр хангах үе	Анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч гарын авлага, тараах материал түгээх, гэрт нь очих, дэмжих	
3	Сонирхол төрөх үе	Уулзалт, сургалт, манлайлагчдын бүлгийн уулзалт, эвсэл, холбоо байгуулах	Шийдвэр гаргагчид, засаг захиргааны байгууллага, нийгмийн ажилтан, бизнес эрхлэгчид, идэвхтэн гишүүд
4	Мэдээлэл хийх үе	Уулзалт, сургалт, манлайлагчдын бүлгийн уулзалт, зөвлөл, удирдах зөвлөл, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа	
5	Туршиж үзэх үе	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, манлайллын сургалт	
6	Даган дууриах үе	Иргэд-иргэдийн манлайлагч-иргэдийн мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх	
7	Хэрэгжүүлэх	Зорилго, зорилт, алсын хараа, хүрэх үр дүн, үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах	Нийгмийн ажилтан зохицуулагч байх,

			холбон зуучлах эвсэл, холбооны гишүүд
--	--	--	--

Иргэд олон нийт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн байгууллагын адил оролцогч, хамтран зүтгэгч байх ёстой гэж үзэх бөгөөд ингэж байж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилгод хүрэх юм. Энэ нь төр болоод хууль сахиулах байгууллагын албан ёсны хяналттай зэрэгцэн оршиж байж үр дүнтэй болдог. Харин цагдаагийн байгууллагын зүгээс тэдний санал санаачлагыг дэмжиж мэргэжлийн үүднээс зөвлөн чиглүүлэх байдлаар дэмжин ажиллах ёстой. Ингэснээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлдэг арга хэмжээнд зарцуулж буй зардлыг хэмнэх боломжтой.

Өсвөр насныхны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог хангах аргын нэг нь оролцооны аргаар тулгамдсан асуудлыг тодорхойлох явдал юм.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь иргэдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар тэдэнд заавар чиглэл өгч удирдахаас илүүтэй үйл ажиллагаа, санаачлагыг нь дэмжих, тухайн нутаг дэвсгэрт үүссэн асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг. Мөн олон нийтэд түшиглэсэн урьдчилан сэргийлэх ажил нь иргэдийн оролцоотой нийгмийн хяналтыг бий болгох, тэд өөрсдөө амьдарч буй орчныхоо тодорхой харилцаа, хэм хэмжээ, дүрэм журмыг тогтоох, түүнийгээ сахих, хоорондоо нэгдэж, аюулгүй байдлаа хангах зэрэг бололцоог бий болгоно. Нөгөө талаас хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа ил тод, ойлгомжтой, иргэдэд нээлттэй байх ёстой.

Хамтын ажиллагаанд суурилсан олон нийт, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа АНУ-ын Wisconsin мужийн гэмт хэргийн гаралт өндөр Racine хэмээх дүүрэгт үүссэн нөхцөл байдал, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар авч үзье. Энэ дүүрэгт ажилгүйдлийн түвшин өндөр, иргэдийн амьжиргааны түвшин доогуур, орлого бага, гудамжинд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа цэцэглэж, танхайрах, хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн гаралт өндөр байв. Уг дүүргийн иргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэж буй цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд итгэл алдарч, зарим үед хууль тогтоомж зөрчигчид, цагдаагийн алба хаагчдын дунд гардаг мөргөлдөөний гэрч болдог байлаа. Энэхүү үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан асуудалд чиглэсэн цагдаагийн байгууллага, иргэдийн хамтарсан зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа нь идэвхжиж, цагдаагийн байгууллага хяналтаа сайжруулан, оршин суугчдын эрх, ашиг сонирхлын төлөө ажиллаж эхэлжээ. Улмаар асуудалд чиглэсэн цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа илтэд идэвхжиж, сууц өмчлөгчдөд чиглэсэн тусгай дүрэм боловсруулан мөрдүүлж эхэлснээр дээр дурдсан зарим гэмт хэргийн гаралт буурч эхэлсэн байна.

Цагдаагийн байгууллага, иргэд, орон нутгийн бизнес эрхлэгчид, сүм хийдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулснаар оршин суугчдын хөршийн холбоог бэхжүүлж чадсан бөгөөд уг зөвлөлийн үйл ажиллагаа эрчимжиж эхэлсэн юм. Мөн уг үйл ажиллагааг орон нутгийн бизнес эрхлэгчдийн зүгээс дэмжиж олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа, зөвлөлийн ажиллах байр худалдан авч өгсөн байна. Улмаар орон нутгийн цагдаагийн байгууллага өөр дүүрэг, суурингийн шаардлагатай зарим байгууллагатай үйл ажиллагаагаа нэгтгэн, арга туршлага солилцож, түүнийгээ орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нэвтрүүлжээ. Хамтын ажиллагаанд суурилсан энэхүү үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн хулгайлах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис худалдах, хүчирхийллийн гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлж, цагдаагийн байгууллагад ирэх дуудлага эрс багассан байна. Түүгээр ч зогсохгүй тухайн орон нутгийн орон сууцны худалдан авалт өсөж, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэж, оршин суугчдын хөршийн холбоо сайжирсан байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтэд түшиглэсэн болон асуудалд чиглэсэн аргачлалыг нэвтрүүлснээр урьдчилан сэргийлэх ажлын үр дүн сайжрах, цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа шинэ шатанд гарах боломжтой.

Үүнээс гадна цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд халуун цэгт суурилсан цагдаагийн үйл ажиллагаа, compStat, хагархай цонхны онолд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа, мэдээлэлд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа зэрэг арга, аргачлал нэвтэрч байгаа нь сайшаалтай.

Ашигласан материал

1. Brown, B. B., Prinstein, M. J., Encyclopedia of Adolescence. Academic Press. 2011.
2. Schneider, S., Crime Prevention: Theory and Practice, CRS Press Tylor & Francis Group. 2010
3. Туяа С. Өсвөр насныхны дундах дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нийгмийн ажил. УБ. 2018.
4. Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 2016. №7.